



Г ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД Г
Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2020 оны 06 № 01/3542.
танай -ны № -т

Г Зөвлөмж хүргүүлэх тухай Г


Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг Зам, тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төвд ажиллаж, автомашины улсын дугаар олголт, бүртгэлийн үйл ажиллагаа, авлигын гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээтэй танилцахад тэдгээрийн хэрэгжилт хангалтгуй, зарим зөрчил нэмж тогтоогдсон тул авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдо зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн дотор хариу ирүүлнэ үү.


Хавсралт 3 хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА



0005499



Зөвлөмж

Зөвлөмж 1. "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-д автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөр авто машинд шилжүүлэх эсэх асуудлыг нарийвчлан зохицуулах;

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 192 дугаар тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-д 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 219 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд автомашины улсын дугаарыг шилжүүлэх, солихтой холбогдуулан "анх олгосон улсын бүртгэлийн дугаарыг 1) орон нутгаас Улаанбаатар хот, 2) Улаанбаатараас орон нутгаагт, 3) нэг аймагт нөгөө аймагт шилжих тохиолдолд тухайн орон нутгийн сери бүхий дугаараар сольж олгоно" гэж зохицуулсан. Гэвч энэхүү заалтыг нэг мөр дагаж хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал, дээрх журамд заасны дагуу орон нутгаас Улаанбаатар, Улаанбаатараас орон нутгаагт, нэг аймагт нөгөө аймагт улсын дугаар шилжүүлэхээр тогтоосон хязгаарлалтыг давж, иргэдийн өргөдөл, хүсэлт болон териин байгууллага, албан тушаалтны албан бичгийн дагуу аймаг, хот дотор улсын дугаар шилжүүлэг хийж байгаа нь авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрдэлийг бий болгож байна.

Автотээврийн хэрэгслийн улсын дугаар шилжүүлэх, солихыг хориглосон зохицуулалтыг хууль тогтоомж, журамд тодорхой тусгаагүй, цахим бүртгэлийн программд автотээврийн хэрэгслийн дугаар шилжүүлэх өгөгдөл хэсгээс шаардлагагүй өгөгдлийг хасаагүйгээс автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг шилжүүлэх, солихтой холбоотой зөрчил гарсаар байна. Тухайлбал, Автотээврийн үндэсний төвийн хоёр албан хаагч ерөнхий бөгөөд ойлгомжгүй эрх зүйн зохицуулалт, хийдлийг далимдуулан тус журам, цахим бүртгэлийн программ ашиглан бусдад давуу байдал олгон, хээл хахууль авсан авлигын гэмт хэрэгт холбогдон Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байна.

Зөвлөмж 2. Өөрт олгогдсон эрх хэмжээг хэтрүүлэн "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-д тусгасан хуулиас давсан зохицуулалтыг хүчингүй болгох, асуудлыг хуульд тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх;

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 376 дугаар тушаалаар "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-д "Автотээврийн хэрэгслийн экспортлогч улсын экспортлооос өмнөх үеийн техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт" гэсэн зохицуулалтыг нэмж тусгасан байна. Энэхүү нэмэлт нь гадаад улсаас техникийн бүрэн бус, осол аваарт орсон автотээврийн хэрэгслийг Монгол Улсад бүртгэхээс сэргийлэх ач холбогдолтой хэмээн Зам, тээврийн хөгжлийн яам, Автотээврийн үндэсний төвийн албан тушаалтнууд тайлбарлаж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан уг журмыг үндэслэн Автотээврийн үндэсний төв Япон улсын "Okayama hulu LLC" компанитай "Монгол Улсуудын импортлогдох автотээврийн хэрэгслийн "Экспортын өмнөх үеийн техникийн хяналтын үзлэг оношилгоо хийх, үзлэг хяналт дууссаны дараа бүртгэсэн мэдээллийн санг үнэ төлбөргүй ашиглаулах, гүйцэтгэснийг илтгэх баталгаат сертификатыг автотээврийн хэрэгсэл тус бүр олгохоор гэрээ байгуулсан байна.

Үүнтэй холбогдуулан Япон улсаас авто машин нийлүүлэгч "Autocom" зэрэг хэд хэдэн компани техникийн хяналтын үзлэгийн төлбөрт нэг машинаас 20000 иен буюу 510000 төгрөг авах болсон байна. Энэ нь Япон, Солонгос улсаас орж ирэх авто машины худалдах үнийг нэмэгдүүлж, Америк, Австрали зэрэг бусад улсаас орж ирсэн машинд хяналт тавих боломжгүй, үр дүнгүй шийдвэр болж болзошгүй байх тул цаашид техникийн бүрэн бус, осол аваарт орсон, удаан хугацаанд ашиглагдсан автотээврийн хэрэгслийг Монгол Улсад оруулж ирэхийг хориглох асуудлыг нэг мөр шийдвэрлүүлэх нь зүйтэй.

Асуудлыг "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-аар зохицуулах бус харин Гаалийн тухай хуулийн (8 дугаар зүйл. "Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглох, хязгаарлах")-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар зохицуулах нь илүү зохистой байна.

Зөвлөмж 3. Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн программийг шинэчлэн сайжруулах, нэвтрэх өөрчлөх эрхийг нэг газарт төвлөрүүлэн, мэдээллийг нэгтгэн харах, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх, журам зөрчиж авто тээврийн хэрэгслийн дугаар шилжүүлэх үйлдлийг цахим шийдлийн тусламжтайгаар таслан зогсоох арга хэмжээг авах;

Автотээврийн үндэсний төвөөс 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс нэвтрүүлсэн <https://burtgel.transdep.mn/> цахим хаягаар автотээврийн хэрэгслийн улсын дугаар захиалах боломжтой болсон. Тус бүртгэлийн программд автомашины улсын дугаар захиалсан байдлыг "Сул", "Олгогдсон", "Хүлээгдэж буй", "Захиалагдсан" гэсэн 4 төлөвтэйгээр хөгжүүлжээ. "Хүлээгдэж буй" гэсэн шар өнгөтэй төлөвт шинээр задарсан серийн "A3"-ын гэгддэг 300 орчим дугаарыг шууд захиалах боломжгүйгээр тохируулж, 14 хоног тутам санамсаргүй байдлаар суларч, хүний оролцоогүй, тохиолдлын байдлаар гарч ирэхээр суулгасан байна. Гэвч уг "A3"-ын гэх ямар дугаар суларч, ямар дугаар үлдсэн талаарх мэдээллийг харах, дүн шинжилгээ хийх, хяналт тавих боломж байхгүй байна.

Авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг иргэд хооронд шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яамнаас улсын дугаарыг шилжүүлэх болон солих эрхийг нь бүртгэлийн программаас хассан байна. Гэтэл тэрийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 7 хоногийн дараа уг үйлдлийг дахин сэргээж автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам" зөрчиж шилжүүлсэн байна. Иймд автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг журмаас гадуур шилжүүлэх боломжийг хаах, автотээврийн хэрэгслийн бүртгэлийн программын тусламжтайгаар таслан зогсоох арга хэмжээг авах нь зүйтэй.

Зөвлөмж 4. Автотээврийн хэрэгслийн улсын дугаар хэвлэх үнийг үндэслэлгүйгээр нэмсэн асуудлыг судлан үзэж, хэвлэх үйлдвэртэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж ажиллах;

“Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам” 2018 онд батлагдснаас хойш улсын дугаарыг хэвлэх үнэ хоёр удаа нэмэгдсэн байна. Тээврийн хэрэгслийн улсын дугаар хэвлэх тусгай зөвшөөрөл бүхий 36 компани нэгэн зэрэг үнээ нэмж, үгсэн хуйвалдсан байж болзошгүй байна.

Улсын дугаарын үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгож, хэвлэх үйлдвэртэй гэрээ байгуулдаг ба гэрээнд улсын дугаарын үнэ нэмэгдэх нөхцөл байдал үүсвэл тус яамнаас зөвшөөрөл авахаар тусгасан байдаг.

Гэвч сүүлийн хоёр удаа улсын дугаар хэвлэх үнэ нэмэгдэхэд Зам, тээврийн хөгжлийн яаманд мэдэгдэлгүй гэрээний заалтыг зөрчиж үнэ нэмсэн үйлдвэрүүдтэй гэрээг цуцлах зэрэг хариуцлагын асуудлыг хөндөөгүй буюу ямар нэгэн бодитой арга хэмжээ аваагүй нь аж ахуйн нэгжүүдийн үндэслэлгүйгээр үнэ хөөрөгдөхийг дэмжсэн, бусдад хууль бус давуу байдал олгосон шинжтэй байна.

Зөвлөмж 5. Албан бус шийдвэр гарган зохиомол хүнд суртал үүсгэж байгааг таслан зогсоож, үйлчилгээний чанар, хуртээмжийг сайжруулах зорилгоор Автотээврийн үндэсний төвийн салбар нэгжүүдэд ажлын байрны зураглал хийх, үйл ажиллагааны процесст тулгарч буй асуудлуудыг судлан холбогдох арга хэмжээг авах гэх мэт бодитой ажлууд хийх;

Эрх бүхий этгээд батлаагүй албан бус шийдвэрийн улмаас зарим үйлчилгээнд зохиомол хүнд суртал гарч байна. Тухайлбал, Автотээврийн үндэсний төв нь автомашины худалдааг Да хүрээ, 22 авто худалдааны төвд төвлөрүүлэх зорилгоор тус худалдааны төвүүдэд гаалийн бичигтэй Монгол Улсад анх орж ирсэн авто тээврийн хэрэгслийг бүртгэж дугаар олгон, бусад төвүүдэд энэхүү үйлчилгээг үзүүлэхгүй байх албан бус шийдвэр гарсан байна. Энэ нь иргэд оршин суугаа газар болон харилцагч банк, нотариаттай ойр Автотээврийн үндэсний төвийн салбаруудаас авто тээврийн хэрэгсэлд улсын дугаар авах боломжгүй, мэдээллийг олон нийтэд бүрэн хүргээгүйгээс иргэдэд чирэгдэл үүсэх нөхцөл бий болжээ.

Мөн хэн, хаанаас гаргасан тодорхойгүй аман шийдвэрээр авто тээврийн хэрэгслийг нэг өдөрт хоёр удаа бусдад шилжүүлэхгүй байх албан бус шийдвэр гаргасан байна. Энэ үйлдлээ улсын дугаарыг бусдад худалдах явдлыг арилгах зорилготой гэж байгаа боловч “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам” болон холбогдох хууль тогтоомжид энэ хүү зохицуулалт огт тусгагдаагүй байна. Дээрх албан бус, аман шийдвэрүүдийн улмаас албан хаагчид хууль тогтоомж зөрчих, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэл нэмэгдсэн байна.